



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/202

Улаанбаатар хот

□ Коронавируст халдвараас урьдчилан □
сэргийлэх, эрсдэлийг бууруулах
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолын 3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/483 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад covid-19 буюу шинэ коронавирусын халдвар тархах, халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор 0-12 насны хүүхэдтэй нийт 16 албан хаагчдыг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд ажлын өдрийн 09:00 цагаас 16:00 цагийн хооронд ажиллахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан өөрсдийн эрүүл мэндэд анхаарч, байгууллагын ажил үүргийг цалгардуулахгүй, иргэдэд хүнд суртал, ачаалал үүсгэхгүй байж холбогдох хууль журмыг баримтлан ажиллахыг албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115030000503